

# ГАЧИГДАГСДЫГ ХАЛАМЖЛАХ НЬ

СУРАЛЦАХ  
ЗААВАР



# ГАЧИГДАГСДЫГ ХАЛАМЖЛАХ НЬ

СУРАЛЦАХ  
ЗААВАР

*Тэр заримыг нь элч, заримыг нь эш  
үзүүлэгч, заримыг нь сайн мэдээг тунхаглагч,  
заримыг нь хоньчин ба багш болгожээ.  
Эдгээр нь ариун хүмүүсийг үйлчлэлийн  
ажилд бэлтгэж, Христийн биеийг  
байгуулахын тулд юм.  
Бид бүгд итгэл хийгээд Бурханы Хүүг  
мэдэх мэдлэгийн нэгдэл хүртэл,  
төлөвшсөн хүн болтол,  
Христийн дүүрэн байдлын чанарын  
хэмжээнд хүртэл ингэх ажээ.*

*Ефес 4:11–13*

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав  
Солт Лейк хот, Юта

© 1986 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан

АНУ-д хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 10/86

Орчуулгын зөвшөөрөл: 10/86

*Caring for the Needy: Study Guide*-ын орчуулга  
Mongolian

# АГУУЛГА

Оршил iv

## Хэсэг 1 Бишоп хэрэгцээ шаардлагыг урьдчилан сануулж, сэрэмжлүүлэн тусалдаг

- Бие даах чадварыг хөхүүлэн дэмж 1
- Харамгүй сэтгэлээр өгөхийг урамшуул 1
- Асуултуудыг нэгтгэн дүгнэ 2
- Дасгал 2
- Бие дааж амьдрах чадварыг хянах маягт 3

## Хэсэг 2 Бишоп нь гачигдагсдыг хайн олж халамжилдаг

- Гачигдагсдыг эрж ол 4
- Нөхцөл байдалд дүн шинжилгээ хий 4
- Ялган таних чадварыг ашигла 4
- Тусламж үзүүл 5
- Тусламж авагчдаар ажил хийлгэ 6
- Асуултуудыг нэгтгэн дүгнэ 6
- Дасгал 7
- Хэрэгцээ ба эх үүсвэрийн шинжилгээ 9

## Хэсэг 3 Бишоп нь гадасны бишопуудын Халамжийн Зөвлөлд оролцдог

- Асуултуудыг нэгтгэн дүгнэ 10
- Дасгал 10
- Санал болгох ажлууд 10

## Нэмэлт эх сурвалжууд


- Судрууд 12
- Дуу бичлэгийн материалууд 12
- Гарын авлагууд 12
- Сүмийн ном хэвлэл дэх өгүүллүүд 12

# ОРШИЛ

Та Их Эзэний зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд бишопоор дуудагдаж, томилогдоод байгаа билээ. Доорх диаграммд харуулснаар таны дуудлагад таван төрлийн үүрэг хариуцлага багтдаг.

Энэхүү суралцах заавар болон дагалдах дүрс бичлэгүүд гачигдагсдыг халамжлах үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд тань туслах арга замуудыг тайлбарладаг. Энд толилуулж байгаа материал энгийн хялбар бөгөөд бишопуудад холбогдолтой бүхэн салбарын ерөнхийлөгчдөд хамаатай.

**Заавар:** “*Caring for the Needy* дүрс бичлэг”-ийн оршил хэсгийг үзэж, дараа нь энэ суралцах зааврын 1-р хэсгийг уншиж, асуултуудад хариул. Хэрэв энэ дүрс бичлэг олдохгүй бол шууд суралцах зааврыг ашигла.



**Хувь** хүн бүр хэрэгцээгээ урьдчилан төлөвлөх үүрэгтэй. Бишопын хувьд таны хүлээх үүрэг бол гишүүд өөртөө, гэр бүлдээ, түүнчлэн бусдад туслахын тулд чадах бүхнээ хийж байгаа эсэхийг хянах явдал юм. Та санваартны чуулгууд болон Нийгмийн Халамжийн Бүлэгтэй хамтран, халамжтай холбоотой сайн мэдээний: бие даах чадвар болон харамгүй сэтгэлээр өгөх гэсэн үндсэн хоёр зарчмыг заах ёстой.

Зарлигуудыг дуулгавартай дагаж, дээрх хоёр зарчмын дагуу амьдарснаар гишүүд материаллаг хэрэгцээнээс зайсхийдэг. Зохистой үлгэр дуурайл үзүүлж, ярилцлага болон цуглаанууд дээр бие даах чадвар болон харамгүй сэтгэлээр өгөх зарчмуудыг онцлон заа. Халамжийн үйлчилгээний хорооны хурлын тодорхой хэсгийг дээрх зарчмуудын сургалт болон түүний дагуу амьдарснаар гарсан өсөлт хөгжлийг хэлэлцэхэд зориул.

### **Бие даах чадварыг хөхүүлэн дэмж**

Бие даах чадвартай хувь хүмүүс өөрсдийн хөдөлмөрөөр өөрсдийгөө болон гэр бүлээ тэжээн тэтгэдэг (Эхлэл 3:19-ийг үз). Тэд хашир хянуур, хөдөлмөрч, арвич хямгач байж, шаардлагагүй өр зээл тавьдаггүй, өндөр настай эцэг эхээ асран халамжилж, болзошгүй аюулд бэлтгэлтэй байдаг (С ба Г 38:30; 78:14-ийг үз).

“Өөрсдийн хэрэгцээт зүйлсийнхээ л төлөө ажиллацгаая. Өөрийгөө аваад явчих чадвартай, бие даасан байдалтай байцгаая. Өөр зарчмаар авралыг олно гэж байхгүй. Аврал нь хувь хүний асуудал. Иймээс материаллаг болоод сүнслэг байдлын аль алинд нь бид өөрсдийн авралыг бий болгох ёстой” (Марион Г.Ромни, in Conference Report, 1976 оны 10-р сар, х. 167; *Ensign*, 1976 оны 11-р сар, х. 124).

“Бие бялдрын эсвэл сэтгэл санааны ачааг өөрийн болон гэр бүлийнхээ сайн сайхны төлөө өөрөө үүрэх боломжтой ч өөр хэн нэгэнд зориудаар үүрүүлдэг хүн жинхэнэ Хожмын Үеийн Гэгээнтэн биш. Харин тэр Их Эзэний сүнслэг нөлөөгөөр, өөрийн болон гэр бүлийнхээ амьдралын сүнслэг ба материаллаг байдлын хэрэгцээг хөдөлмөрийнхөө үрээр хангах ёстой” (Спенсер В.Кимбалл, in Conference Report, 1977 оны 10-р сар, х. 124; *Ensign*, 1977 оны 11-р сар, х. 77–78).

Гишүүдэд Санваартны чуулгууд болон Нийгмийн Халамжийн Бүлэг нь бие дааж амьдрах ур чадварт суралцахад тусалдаг. Эдгээр нь бичиг үсэгт сургах, боловсрох, ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх, санхүүгийн менежмент, гэрийн үйлдвэрлэл ба нөөцлөлт хийхэд суралцах болон бие бялдрын, нийгмийн, сэтгэл санааны өв тэгш байдалд суралцахад чиглэсэн байж болно.

Бие дааж амьдрах чадвартай болоход нь гишүүдэд туслах хяналтын маягт хуудас 3 дээр байгаа. Та бие дааж амьдрах чадварыг урамшуулан дэмжиж, хяналтын маягыг бөглөхийг гишүүд, гэр бүлүүдээс хүсэх замаар тойрог дахь халамжийн хэрэгцээг урьдчилан төлөвлөхөд тусалж чадна.

### **Харамгүй сэтгэлээр өгөхийг урамшуул**

“Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй” (Үйлс 20:35) гэж Их Эзэн хэлсэн байдаг. Гишүүд “Та нар хүн бүр байгаагийнхаа хэрээр ядуустай хөрөнгөө хуваалцаасай хэмээнэ би” (Мозая 4:26) хэмээх тунхаглалын үзэл санаагаар цаг зав, авьяас чадвар, нөөц боломжоо хуваалцсанаар харамгүй сэтгэлээр өгдөг. Тэр ч байтугай өчүүхэн бага

юмтай хүн ч өгч чадна (Мозая 4:24-ийг үз). Мацгийн өргөлөө өгч, гэр бүл, Сүм, нийгэмд энэрэнгүй сэтгэлийн үйлчлэл үзүүлэхэд тойргийн гишүүдийг урамшуулж, харамгүй сэтгэлээр өгөхийг хөхүүлэн дэмж.

*Мацгийн өргөл нь* хамгийн багаар, мацгийн үед идээгүй хоёр хоолны үнэтэй тэнцүү байх ёстой. Боломжтой бол гишүүд үүнээс илүүг өгч болно.

“Бид чинээлэг хангалуун байгаа үедээ өгөөмөр байж. . . мацаг барьсан хоёр хоолны үнэнээс илүү ихийг, магадгүй бүр илүү ихийг–арав дахин ихийг боломжтой байхдаа өгөх ёстой гэж би боддог.” (Спенсер В. Кимбалл, in Conference Report, 1974 оны 4-р сар, х. 184).

Бүх гишүүд *Энэрэнгүй сэтгэлийн үйлчлэлийг* үзүүлэх ёстой. “Ядуус хийгээд гачигдагсад, өвчтөнүүд хийгээд зовж шаналагсдыг бүх зүйлээр санаж байгтун. Учир нь үүнийг үл хийдэг тэрээр, мөнхүү тэр нь миний шавь биш бөлгөө” (С ба Г 52:40) хэмээн Их Эзэн тушаасан. Гишүүд өөртөө туслахын тулд чадах бүхнээ хийснээр бусдад гар сунган туслах хүслээр адислагддаг билээ. Ийм хүсэл нь хуваалцах, зохион байгуулалттай үйлчлэлийн төслүүдэд болон нийгмийн үйлчлэлд, ялангуяа гачигдагсад туслахад оролцох байдлаар илэрдэг юм.

Гишүүд, удирдагчид эдгээр зарчмуудад дуулгавартай байснаар Сионыг ойртуулдаг. “Их Эзэн өөрийн хүмүүсийг Сион хэмээн нэрлэв. Учир нь тэд нэг зүрх сэтгэл мөн нэг оюунтай байлаа, мөн зөв шударга ёсонд оршин сууж байлаа. Бас тэдний дунд ядуус байсангүй” (Моше 7:18; 7:17-г үз).

**Заавар:** “*Caring for the Needy*” дүрс бичлэгийн 1-р хэсгийг үзнэ үү.

### Асуултуудыг нэгтгэн дүгнэ

Эл суралцах зааврын 1-р хэсгийг уншиж, “Caring for the Needy” дүрс бичлэгийн 1-р хэсгийг үзсэний дараа дараах асуултуудад хариул. Та эдгээр материалыг нэгтгэн дүгнэх үед мэдэрсэн сүнсний өдөөлтүүдийг тэмдэглэж болно. Энэ тэмдэглэл чинь сургалт дууссаны дараа бодол санаагаа эргэн санаж, эмхлэхэд тань тусална.

1. Хэрэгцээг урьдчилан төлөвлөхөд хэн гол үүргийг гүйцэтгэдэг вэ?
2. Хэрэгцээг урьдчилан төлөвлөхөд санваартны чуулгууд, Нийгмийн Халамжийн Бүлэг ямар үүрэг хариуцлагатай байдаг вэ?
3. Хэрэгцээг урьдчилан төлөвлөхөд та ямар үүрэг хариуцлагатай вэ?

4. Танай тойргийн гишүүд ямар арга замаар илүү их бие дааж амьдрах чадвартай болох вэ?

5. Тойргийн гишүүдийг илүү ихээр харамгүй сэтгэлээр өгөхийг урамшуулан дэмжихийн тулд та юу хийх вэ?

### Дасгал

Бие дааж амьдрах чадварыг хянах маягтыг өөрийн гэр бүлийн хамт бөглө. Хувийн болон гэр бүлийн зорилгоо тавь. Энэ дасгалыг гүйцэлдүүлснээр та энэхүү үнэ цэнэтэй арга хэрэгслийг ашиглахад Санваартны чуулгууд болон Нийгмийн Халамжийн бүлэгт илүү сайн туслах болно.

**Заавар:** Суралцах зааврын 2-р хэсэг уруу ор.

### **Бие дааж амьдрах чадварыг хянах маягт**

Асуултууд

Ажлын төлөвлөгөө

- Танд өөрийнхөө болон гэр бүлийнхээ хэрэгцээг хангах ажил болон орлогын бусад баттай эх үүсвэр бий юү?
- Та шаардлагагүй өр зээлээс зайлсхийхийн тулд мөнгө санхүүгээ яаж зохицуулдаг вэ?
- Болзошгүй өвчлөл, гэнэтийн аюул осол эсвэл тэтгэвэрт гарахад та санхүүгийн талаар бэлтгэлтэй байгаа юү?
- Та эд хогшил, өмч хөрөнгөө сайн нөхцөл байдалд байлгаж байна уу?
- Та өөрийгөө болон гэр бүлээ Сүмээс, төр засгаас, тэрчлэн бусад хүмүүсээс хараат биш, бие даасан байдалтай байлгаж чадах уу?
- Та бие бялдраа эрүүл чийрэг байлгаж, биеийнхээ жинг зохих хэмжээнд байлгахын тулд чадах бүхнээ хийдэг үү?
- Та осол, гэмтэл бэртэлтээс урьдчилан сэргийлэх зуршлуудыг дагадаг уу?
- Та өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд тэжээллэг хоол хүнс хэрэглэж, эрүүл ахуйг сахидаг уу?
- Та энгийн өвчлөл, гэмтэл бэртлийг эмчилж чаддаг уу? Мөн шаардлага гарсан үед эмнэлгийн тусламж хүсдэг үү?
- Та амьдралдаа тохиолдсон нийгмийн болон сэтгэл санааны сорилтуудыг шийдвэрлэх чадвартай юү?
- Өөртөө болон гэр бүлдээ анхаарал халамж тавихын тулд унших, бичих, шаардлагатай тооны үндсэн үйлдлүүдийг бодож чаддаг уу?
- Та ажлын зөв зуршилтай юү?
- Гэнэтийн аюулын үед хэрэглэх зохих хүнс, хувцас, бусад нөөц танд байгаа юү?



Төлөөлөгч Петр Есүсийг “сэтгэлийн чинь Хоньчин болон Харгалзагч” (1 Петр 2:25) гэж нэрлэсэн байдаг. Бид Аврагчийн үлгэр жишээг судалснаар хоньчин сүргээ удирддагийг хардаг. Хоньчин хонь бүрдээ анхаарал халамж тавьдаг. Тэр хоньдоо мэддэг бас хоньд нь түүний дууг таньж, дуулгавартай дагадаг билээ.

Та Их Эзэний сүргийн дунд Түүнийг төлөөлдөг учраас амьдрал нь гундуухан яваа хүмүүсийг анхаарч халамжлах ариун үүргийг Тэрээр танд итгэмжлэн хүлээлгэсэн юм.

Сургаал ба Гэрээнд ядуусыг анхаарч халамжлах тухай Их Эзэний тусгайлан дүрсэлсэн бүх эрх мэдэл, үүрэг хариуцлага бишопт оногддог билээ. . . . Энэ хариуцлагыг өөр хэн ч үүрдэггүй, энэ ажилд шаардлагатай эрх мэдэл, чиг үүргийг өөр хэнд ч олгодоггүй. . . .

Бишопт Сүмийн ядуусыг өөрийн бүрэн эрхээр, дан ганц өөрийн шийдвэрээр анхаарч халамжлах нь Их Эзэний үгээр оногддог билээ. . . . Сүмийн сангаас тойргийнхоо аль нэг гишүүнд тусламж болгон хэнд, хэзээ, хэрхэн, хэдий хэмжээний зүйл өгөхийг, шийдэх нь бишопын үүрэг мөн.

“Энэ нь Их Эзэн Өөрөө бишопт оногдуулсан эрхэм дээд, хүндтэй үүрэг хариуцлага юм. Бишоп энэ үүргээс зугтаж чадахгүй. Тэр зайлсхийж ч чадахгүй. Тэр ажлаа хөнгөвчлөхийн үүднээс энэ үүргийг өөр хэн нэгэнд шилжүүлж чадахгүй. Бишоп ямар ч тусламжийг дуудсан түүний үүрэг хариуцлага хэвээр үлдэнэ” (Бага Ж.Рюбен Кларк, Марион Г.Ромни эш татжээ, in Conference Report, 1977 оны 10-р сар, х. 115; *Ensign*, 1977 оны 11-р сар, х. 79).

Та Их Эзэний танд туслуулахаар дуудсан хүмүүс болох өөрийн чинь зөвлөхүүд, Мелкизедек санваартны

чуулгын удирдагчид, Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчдын хүч чармайлтаар дамжуулан ихэнх ажлаа амжуулах болно. Тэд таны удирдлага дор ажиллан ядуусыг эрж олоход тусалж, ямар тусламж олгохыг болон халамжийн тусламж хүлээн авсан хүмүүсийг бие дааж амьдрах чадвартай болоход нь туслах ямар ажлыг тэднээр хийлгэхийг зөвлөмж болгож болно.

### Гачигдагсдыг эрж ол

Тусламж хэрэгтэй гишүүдийг эрж олох нь бишоп таны үүрэг мөн. Тэд тусламж хүсч тан дээр ирсэн үед л тэдний хүсэлтэд хариулах нь хангалтгүй юм.

Та үр өгөөжтэйгөөр үйлчлэхийн тулд тойргийнхоо гишүүдийн сүнслэг байдал, бие бялдар, санаа сэтгэл, эдийн засгийн байдалд мэдрэмтгий байх хэрэгтэй.

“Бишоп бүр *тойргийнхоо гишүүдийн ерөнхий нөхцөл байдлыг мэддэг* байх ёстой. Үүнийг тэрээр ажиглалтаар, айлчлагч болон гэрийн багш нарын тайлангаас, ярилцлагаас, түүнчлэн Сүнсний шивнэлтүүдээр мэддэг” (Марион Г.Ромни, in Conference Report, 1979 оны 10-р сар, х. 138; *Ensign*, 1979 оны 11-р сар, х. 95).

Тойргийнхоо гачигдалтай гишүүдийг олж тогтоох арга замуудад дараах зүйлүүд орно.

1. *Сүнсний өдөөлтүүд*. Онцгой дуудлагын тань улмаас тусламж хэрэгтэй хэн нэгний аж байдлын талаар ямар ч үед асуухад Сүнс таныг өдөөж болно. Та тойргийн гишүүдтэй холбоотой байхын хамт нуугдмал хэрэгцээг илрүүлэхийн тулд сонор соргог байж, Сүнснийг сонсож байх хэрэгтэй. Үргэлж Сүнсний өдөөлтөөр ажилла.
2. *Тойргийн халамжийн үйлчлэлийн хороо*. Энэ хороо хуралдах үеэр

Мелкизедек Санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчдын халамжийн хэрэгцээний талаарх тайланг сонс. Халамжтай холбоотой бүх асуудлыг нууц байлга. Мэдээлэл авах, ажил хариуцуулах, өсөлтийн тайлан гаргуулахад халамжийн үйлчлэлийн хороог ашигла.

3. *Гэрийн болон айлчлагч багшийн заалт*. Гэрийн болон айлчлагч багш нар бүх гишүүдийн гэрээр тогтмол очиж байхад анхаар. Тэд гэр бүл бүрийн аж байдлын талаар асууж, чадах хэрээрээ тухайн гэр бүлийн хэрэгцээг шийдвэрлэж байх ёстой. Тэднийг өөрсдийнх нь ажиглаж мэдсэн халамжийн хэрэгцээний талаар хуваалцахыг хүс.

### Нөхцөл байдалд дүн шинжилгээ хий

Та гачигдагсдад туслахдаа тухайн асуудлын мөн чанар, үргэлжилж байгаа хугацаа, түүнчлэн уг хэрэгцээг хангах нөөц боломжуудад нягт няхуур дүн шинжилгээ хийх юм бол хэзээ, хэрхэн туслах талаарх тодорхойгүй байдлыг шийдвэрлэж чадна (С ба Г 9:8–9-ийг үз). Ийм дүн шинжилгээ хийхэд Мелкизедек санваартны чуулгын удирдагч, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нарыг тохиромжтой үед оролцуулж бай.

Хэрэгцээ ба нөөцүүдийг шинжих маягт нь хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, боломжтой нөөцүүдийг тогтооход тань туслах болно (PGWE1293; энэ удирдамжийн хуудас (8)-г үз). Энэ маягтыг бүх газарт хэрэглэдэг.

### Ялган таних чадварыг ашигла

Бишоп танд ядуус, гачигдагсдад ямар тусламж үзүүлэхийг шийдэх боломжийг олгодог ялган таних бэлэг амлагдсан билээ (С ба Г 46:27–30-ийг үз).

“Сүнсний энэхүү чиглүүлээр, би хэнд туслах ёстой вэ? Би хэр зэрэг их тусламж өгөх ёстой вэ? Хэр ойр, хэр зэрэг урт хугацаагаар туслах ёстой вэ? гэсэн байнга давтагддаг асуултуудын хариу илчлэлтээр өгөгддөгийг бишопууд та нар мэдэх болно. Эдгээр асуултуудад хариулах амар хялбар, бэлэн дүрэм байдаггүй. Та олон нийтийн шүүгчийн хувьд асуулт бүрийн хариуг зөвхөн ганцхан эх сурвалж-тэнгэрийн сүнслэг нөлөөнөөс олж авахуйц зохистой амьдрах ёстой” (Марион Г.Ромни, in Conference Report, 1979 оны 10-р сар, х. 140; *Ensign*, 1979 оны 11-р сар, х. 96).

### Тусламж үзүүл

Та эхлээд ямар тусламж үзүүлэхийг шийдэхийн тулд тухайн хувь хүн болон гэр бүлийн нөөцийн хэр хэмжээг тодорхойлох ёстой. Аж байдлаа өөд нь татахад, бусдаас хамааралтай байх биш, харин бие дааж амьдрах чадвараа хөгжүүлэхэд нь хүмүүст туслахын тулд халамжийн тусламжийг олгодог юм. Ёс суртахууны эрхэм чанар, өөрийгөө хүндэтгэх, нэр төрөө эрхэмлэх болон зан төлвийн эрүүл чанарыг тусламж үзүүлсэн хүн бүрд төлөвшүүлэхийг эрэлхийл. Энэ нь бүрэн дүүрэн бие дааж амьдрах чадвар уруу хөтөлнө.

Тусламж үзүүлэхдээ дараах удирдамжуудыг баримтал:

1. *Их Эзэний агуулахыг ашигла.* Их Эзэний агуулах гэдэг бол Сүмийн итгэлтэй гишүүдийн цаг зав, авьяас билэг, ур чадвар, өрөвч сэтгэл, өргөл болгосон материал, мөнгөн хөрөнгө юм. Их Эзэний агуулахыг газар бүрийн ядуус, гачигдагсад туслахад зориулж ашигладаг. Эдгээр нөөц боломжуудыг ашиглан, Их Эзэний өөрийнх нь замаар гачигдагсдыг халамжлах нь өгөгч, авагч хоёрт хоёуланд нь адислал болдог билээ (С ба Г 104:16-г үз).

Мацгийн өргөлийн сан бол гачигдалтай гишүүдэд туслах үндсэн эх үүсвэр юм. Та мацгийн өргөлийн санг ядуучуудад зориулан хүнсний зүйл, хувцас хунар, орон байр, эмнэлгийн тусламж, тэрчлэн бусад зүйлсийг худалдан авахад ашиглаж болно. Мацгийн өргөлийн санг зөвхөн гачигдалтай хүмүүст шууд тусламж үзүүлэхэд ашиглана.

Та мөн орон нутагт чинь боломжтой бол Сүмийн халамжийн нөөц болох Бишопын агуулах, ХҮГ Нийгмийн Үйлчлэл, Дезерет Индастриз, хүнс нөөшлөх үйлдвэр, ажил эрхлэлтийн төв, бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг ашиглаж болно.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийг тусламж үзүүлэхэд оролцуул. Тэр гишүүдийн гэрээр очиж, хэрэгцээтэй үндсэн нэр төрлийн хоол хүнс, хувцас хунар зэргийн жагсаалт гаргаж, захиалгыг хийн хянуулахаар танд өгөх ёстой. Эдгээр зүйлсийг бишопын агуулахаас авах уу, орон нутгийн худалдаачнаас авах уу гэдэгт таны гарын үсэг эрх олгоно.

2. *Харилцан санаа тавьж тусал.* Бишоп, тусламж хүлээн авагч хоёр тусламжийн төрөл, хэмжээ, хугацааг тохиролцох ёстой.
3. *Түр хугацааны тусламж үзүүл.* Сүмийн тусламжийг ихэвчлэн түр хугацааны хэрэгцээг шийдвэрлэхийн тулд олгодог. Урт хугацааны асуудлын шийдлийг олохын тулд санваартны чуулгууд болон Нийгмийн Халамжийн Бүлэгтэй хамтран ажилла. Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настангууд, тэрчлэн урт хугацааны тусламж шаардлагатай бусад хүмүүс амьдрал ахуйгаа авч явахын төлөө өөрсдийнхөө хийж

чадах бүхнийг хийх боломжийг олгох хэрэгтэй.

4. *Амьдралыг тэтгэх нэн тэргүүний хэрэгцээт зүйлсээр тусламж үзүүл.* “Бид тухайн үеийн амьдралын түвшинг хадгалахын төлөө биш, харин хүмүүсийн гачигдаж байгаа нэн тэргүүний хэрэгцээт бараа материал, үйлчилгээгээр тусламж үзүүлдэг. Хувь хүмүүс болон гэр бүлүүд амьдрал ахуйгаа өөд татаж, хэрэгцээгээ өөрсдөө хангахын төлөө чадах бүхнээ хийх хэрэгтэй” (Томас С.Монсон, “Guiding Principles of Personal and Family Welfare,” *Ensign*, 1986 оны 9-р сар, х. 5).
5. *Нийгмийн нөөц боломжуудыг ашигла.* Нийгмийн зүгээс иргэдэд үзүүлдэг үйлчлэл нь гачигдалтай гишүүдэд туслахад ашиглах нэг эх үүсвэр байх ёстой. Ийм үйлчилгээнд гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт семинар, нөхөн сэргээх төвүүд, ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх агентлагууд багтана. Хэрэв гишүүд тусламжийн эдгээр нөөцүүдийг хөөцөлдөж байгаа бол сайн мэдээний зарчмуудыг чанд баримтлан, Халамжийн Үйлчлэлийн Ерөнхий Хорооны бодлогын дараах мэдэгдэлд анхаарлаа хандуулахыг тэдэнд зөвлө:

“Бие бялдрын эсвэл сэтгэл санааны ачааг өөрийн болон гэр бүлийнхээ сайн сайхны төлөө өөрөө үүрэх боломжтой ч өөр хэн нэгэнд зориудаар үүрүүлдэг хүн жинхэнэ Хожмын Үеийн Гэгээнтэн биш. Харин тэр Их Эзэний сүнслэг нөлөөгөөр, өөрийн болон гэр бүлийнхээ амьдралын сүнслэг болон материаллаг байдлын хэрэгцээг хөдөлмөрийнхөө үрээр хангах ёстой...”

“Их Эзэний Сүнсээр удирдуулж, эдгээр зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлснээр Сүмийн гишүүн бүр төр засгийн байгууллагаас эсвэл бусад эх үүсвэрээс ямар тусламж хүлээн авах тухайд шийдвэрээ гаргах ёстой. Ингэх юм бол бусдаас хамааралгүй байх, өөрийгөө хүндлэх, нэр төрөө эрхэмлэх болон бие дааж амьдрах чадварыг хөхүүлэн дэмжиж, чөлөөтэйгөөр сонгох эрхийг урамшуулах болно” (*Welfare Services Resource Handbook* [1980], p. 21).

Гишүүдэд Засгийн газраас мөнгөн тусламж авахыг зохицуулсан аливаа хуулийг мөрдөхийг, ялангуяа Сүмийн тусламж хүлээн авахдаа дагаж мөрдөхийг зөвлө.

### **Тусламж авагчдаар ажил хийлгэ**

Ажил бол сүнслэг болон материаллаг байдалд хоёуланд нь чухал. Сүмийн халамжийн зорилгыг тайлбарлаж, Тэргүүн Зөвлөл хэлэхдээ: “Бидний үндсэн зорилго бол залхуурлын зүхэл, ажилгүйдлийн тэтгэмжийн хилэнцийг устгаж, аль болох бусдаас хамааралгүй, хөдөлмөрч, арвигч хямгач, өөрийгөө хүндлэх явдлыг манай хүмүүсийн дунд эгнэгт төлөвшүүлэх явдал мөн. Сүмийн зорилго бол хүмүүст амьдралаа өөрсдөө авч явахад нь туслах явдал мөн. Ажил хөдөлмөр манай Сүмийн гишүүдийн амьдралд ноёрхогч зарчим болон дээдлэгдэх ёстой” (in Conference Report, 1936 оны 10-р сар, х. 3).

Халамжийн тусламж авсан гишүүд хүлээж авсан зүйлийнхээ төлөө өөрийн чадлаар ажил хийх ёстой. Ажил хийх нь тусламж хүлээн авагчийг тусламж авах эрхтэй болгож, бие даасан байдал, ажил хөдөлмөрийг эрхэмлэн, арвигч

хямгач, өөрийгөө хүндлэх хүндэтгэлийг хөгжүүлэхэд тусалдаг.

Тусламж авагчдад ажил өгч хийлгэхдээ дараах зөвлөмжүүдийг баримтал:

1. *Харилцан зөвлөлдсөний үндсэн дээр хийх ажлыг өг.* Бишоп, тусламж авагч хоёр ажлын маягт, үргэлжлэх хугацааг тохиролцоо ёстой.

“Хэрэв тухайн хүн чадвартаа тохирсон ажил хийхээс татгалзвал, зан төлөв нь өөрчлөгдөн шинэчлэгдэх хүртэл түүнд тусламж үзүүлэхээс татгалзах бүрэн эрх бишопт бий” (Марион Г.Ромни, in Conference Report, 1979 оны 10-р сар, х. 139; *Ensign*, 1979 оны 11-р сар, х. 96).

2. *Тусламж хэрэгтэй бусад гишүүдэд туслах ажил хийлгэ.* Нэг хүний ажил нөгөө хүндээ тусалж, орон нутаг дахь хэрэгцээг шийдвэрлэн, бие биедээ үйлчлэхэд нь гишүүдэд туслах ажил хийлгэхийг хичээ.

3. *Зорилго чиглэлтэй ажил хийлгэ.* Боломжтой бол даалгасан ажил нь бие дааж амьдрах чадвартай болоход тухайн хүнд тусалдаг байх ёстой.

4. *Тойргийн халамжийн үйлчлэлийн хороог оролцуул.* Хийх ажил олж өгөх бүтээлч олон арга зам бий. Тусламж авагчдад ажил олж хийлгэхэд хорооны гишүүдийг оролцуул.

Та ажил хийх даалгавар өгөхдөө “Санал болгох ажлууд”-ыг эргэн харахыг хүсч болно (суралцах зааврын хуудас 9-ийг үз). Хэрэгцээ ба Нөөцүүдийг шинжих маягтын хоосон зайнд хийлгэх ажлыг бич.

**Заавар:** “*Caring for the Needy*” дүрс бичлэгийн 2-р хэсгийг үзнэ үү.

### **Асуултуудыг нэгтгэн дүгнэ**

Суралцах зааврын 2-р хэсгийг уншиж, “*Caring for the Needy*” дүрс бичлэгийг үзсэний дараа, дараах асуултуудын хариуг бич. Эл материалыг нэгтгэн дүгнэх үед төрсөн мэдрэмжээ та тэмдэглэж болно. Энэ тэмдэглэл нь сургалт дууссаны дараа бодол санаагаа эргэн санаж, хэрэглэхэд тань туслах болно.

1. Бишопт халамжийн үйлчлэлийн ямар үүргүүд байдаг тухай ойлгосон зүйлсээ өөрийн үгээр бич.

2. Тойргийнхоо гишүүдийн хэрэгцээг хангахын тулд та бусдын (түүний дотор тойргийн халамжийн үйлчлэлийн хороог) хичээл зүтгэлийг хэрхэн ашиглах вэ?

3. Гачигдалтай гишүүдийг олохын тулд та ямар алхмуудыг хэрэгжүүлэх вэ?

### **Дасгал**

Өөрийн тойрог дахь тусламж шаардлагатай байгаа хувь хүн, гэр бүлийг тогтоо. Хэрэгцээ ба нөөцүүдийг шинжих маягтыг тухайн гэр бүлтэй хамт бөглө. Энэ дасгалыг хийснээр та хойшид хэрэгцээнд дүн шинжилгээ хийх бүрдээ маягтыг ашиглах сайн чадвартай болно.

**Заавар:** Суралцах зааврын 3-р хэсгийг үз.

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

**Хэрэгцээ ба Эх Үүсвэрийн Шинжилгээ** Бие Дааж Амьдрахад Туслах Төлөвлөгөө  
Гишүүний нэр

Хаяг		Утас
Хэсэг	Гадас	
Хаана ажилладаг	Эрхэлдэг ажил	Утас

Асаргаанд байдаг гэр бүлийн гишүүдийн нэр, нас

**Зааврууд**

Бишоп нь хэсгийн халамжийн хорооны хувьд пристийн зэрэгтний чуулга болон Нийгмийн Халамжийн бүлгийн удирдагчдыг хамруулан хувь хүмүүст тулгамдсан үед нь бие дааж амьдрахад нь туслах төлөвлөгөөг боловсруулж мөрдөхөд нь тусалдаг.

1. Хувь хүний болон гэр бүлийнх нь хэрэгцээг тодорхойлох.
2. Хувь хүн, гэр бүл, Сүмийн болон бусад эх сурвалжуудыг тодорхойлох.
3. Бие дааж амьдрах төлөвлөгөө боловсруулахад нь гишүүнд туслах.
4. Гишүүний чадварт нь тохирсон ажил үүргийг хувиарлаж өгөх.

Хойшлуулашгүй Хэрэгцээ	Хойшлуулашгүй Хэрэгцээг Хангах Эх Үүсвэрүүд
Гишүүнтэй хамтран түүний хойшлуулашгүй хэрэгцээг тодорхойл. Хэрэгцээг дор харуулсан байдлаар жагсаалт гаргаж болох бөгөөд хоол хүнс, хувцас хунар, орон гэр, эм болон ахуйн хэрэглээний зардал болон бусад зүйл багтана.	Хувь хүн, гэр бүл, хэсгийн халамжийн хороо, Сүмийн бусад эх үүсвэрүүд түүнчлэн хамт олны эх үүсвэрүүд. 1. Хувь хүний эх үүсвэрүүд
	2. Гэр бүлийн гишүүд хийгээд тэд (эцэг эхчүүд, хүүхдүүд, ах эгч дүүс болон бусад) хэрхэн тусалж чадах.
	3. Бусад эх үүсвэрүүд хийгээд тэдгээр нь хэрхэн тусалж чадах.

Бие Даахад Шаарлагдах Хэрэгцээ	Бие Даахад Шаарлагдах Хэрэгцээг Хангах Төлөвлөгөө
<p>Бие дааж амьдрахад нь юу шаардлагатай байгааг уг гишүүнтэй хамтран тогтоо. Хэрэгцээг дор харуулсан байдлаар жагсаах ёстой бөгөөд үүнд гэр орон, ажил хөдөлмөр, мэргэжлийн сургалт, боловсрол зэрэг хамарч болно.</p>	<p>Шаардагдаж байгаа эх үүсвэрүүдийг, мөн ямар хугацаанд, хэрхэн олохыг заасан бие даах чадварын төлөвлөгөөг гишүүнтэй хамтран боловсруул.</p>

**Гүйцэтгэх Ажил Буюу Үйлчилгээ** Хүлээн авсан эд материал буюу үйлчилгээний төлөө чадвартаа тохирох ажилд гэр бүлийн гишүүдийн хүлээн зөвшөөрсөн үүрэг даалгаврыг дор тэмдэглэ.

<b>Гарын үсгүүд</b>			
Гишүүний гарын үсэг	Он сар өдөр	Бишопын гарын үсэг	Он сар өдөр

Анхаар: Тус маягтан дээрх бишоп, хэсэл гэдэг нь мөн түүнчлэн *салбарын* ерөнхийлөгч, салбарыг зааж байгаа болно.

Та бишопуудын зөвлөлд оролцсоноор—

1. Гачигдагсдыг эрж олох, хэрэгцээнд дүн шинжилгээ хийх, тусламж үзүүлэх, ажил хийлгэх зэрэг халамжийн үүргүүдийн талаарх сургалтанд хамрагдана. Заримдаа гадасны ерөнхийлөгчийн зөвлөл оролцон, заавар өгч болно.
2. *Санал ба туршлага солилцох нь* үүрэг хариуцлагаа мэдэж, хүнд асуудлуудын шийдлийг олоход тань туслах болно.
3. *Орон нутгийн нөөц боломжийг* илрүүлж, эдгээр нөөцүүдээс гишүүд ашиглах боломжтойг нь та тогтоож болно.
4. Мацгийн өргөл, халамжийн хэрэгцээ ба тусламжийн чиг хандлагыг нэгтгэн дүгнэ. Хэрэгцээг өөрчлөх, Сүмийн халамжийн нөөцийг буруугаар ашиглаж болзошгүй тохиолдолд сонор соргог бай.
5. Хувь хүний хувиар энэрэнгүй сэтгэлийн үйлчлэлийг хийхэд залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийг оролцуулах арга замуудыг олоход онцгой анхаарлаа хандуулж, сүмийн бүх гишүүдийн дунд халамжийн үйлчлэлийг хэрхэн урамшуулан дэмжих талаар хэлэлц. Мацгийн өргөлийг цуглуулахад Аароны санваар эзэмшигчдийг ашиглах арга замыг авч үз.
6. *Сүмийн халамжийн нөөцүүд* (хаа байгаа газарт)-ийн үйл явц, менежмент-д үнэлэлт өг. Тусламж авагчид тэдгээр газруудад ажиллах боломжийг олж тогтоо. Сайн дурын ажил болон шаардлагатай бусад нөөцүүдийг олж тогтоо.

7. *Боломжтой ажлыг тогтоож,* гишүүд хүлээн авсан зүйлийнхээ төлөө өөрсдийн чадвараар ажиллах арга замуудын тухай ярилц.
8. Халамжийн тусламж хэрэгтэй байгаа хүмүүстэй санваартны чуулгууд болон Нийгмийн Халамжийн бүлгүүд хамтран ажиллаж болох арга замуудын тухай ярилц.

**Заавар:** “Caring for the Needy” дүрс бичлэгийн 3-р хэсгийг үз.

### Асуултуудыг нэгтгэн дүгнэ

Суралцах зааврын 3-р хэсгийг уншиж, “Caring for the Needy” дүрс бичлэгийг үзсэний дараа, дараах асуултуудын хариуг бич. Эл материалыг нэгтгэн дүгнэх үед төрсөн мэдрэмжээ та тэмдэглэж болно. Сургалт дууссаны дараа бодол санаагаа эргэн санаж, хэрэглэхэд тань энэ тэмдэглэл туслах болно.

1. Гадасны бишопын халамжийн зөвлөлөөр халамжийн ямар асуудлуудыг хэлэлцэхийг та хүсэх вэ?
2. Та гадасны бишопын халамжийн зөвлөлөөс Халамжийн үүргээ илүү үр өгөөжтэйгөөр биелүүлэхэд тань туслах юуг сурсан бэ?

3. Зөвлөлийн хурлууд дээр эсвэл сургалтын үеэр авч үзэх шаардлагатай гэж өөрийнхөө боддог сэдвүүдийг жагсаа.

### **Дасгал**

Халамжийн тусламж авагчдад үр ашигтай байж болох ажлуудыг жагсаан бич. (Та дараах санал болгох ажлуудын жагсаалтыг ашиглаж болно.) Энэ дасгалыг хийх нь гадасны бишопын халамжийн зөвлөлийн хуралд цаашид оролцоход бэлтгэхэд тань тусална.

### **Санал болгох ажлууд**

Санал болгох ажлуудын жагсаалт нь бишоп сүмээс тусламж авсан хүмүүст тохиромжтой ажил олж хийлгэхэд туслах юм. Энэ жагсаалтыг хянан үзэж, өөрийн бүсэд байдаггүй санал болгох аливаа ажлыг хасч, орон нутагт тань боломжтой ажлуудыг нэмж оруул.

- A. Сүмийн цуглааны байр болон газар шорооны ажил:
1. Будах ба засварлах
  2. Барилгын төслүүд
  3. Халаалтын тоног төхөөрөмжийг харж, арчлах
  4. Харуул жижүүрүүдэд туслах
  5. Бүт сөөгийг тайрч засах
  6. Зүлэг хадаж, цэцгийн мандлыг арчилж тордох
  7. Цэцэг тарьж ургуулах
  8. Цас арилгах
  9. Олон нийтийн арга хэмжээний үеэр харуул жижүүрүүдэд туслах

### **Б. Бусад ажлууд:**

1. Тойргийн бичиг хэргийн ажилтнуудад бүртгэл тайлангийн ажилд нь туслах
2. Номын санчдад туслах
3. Өвчтэй, ядуу, өндөр настангуудын гэрийн ажилд нь туслах
4. Хичээл сурлагаараа доголдож байгаа оюутан, сурагчдад туслах
5. Тойргийн түүх болон үйл ажиллагаатай холбоотой сүмийн чухал мэдээ баримтуудыг цуглуулж, эмхэтгэх
6. Тойрог дахь бусад хүмүүст ажил мэргэжлийн үр чадварыг заах
7. Ажил хийдэг эхчүүдийн хүүхдийг, тэрчлэн сүмийн цуглаануудын үеэр хүүхдүүдийг харж, хандах

Хэрэв та бишопын агуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүд, хүнс нөөшлөх үйлдвэр, Дезерет Индастрийз, ажил эрхлэлтийн төвүүдтэй холбоотой байдаг бол эдгээр газрын менежертэй холбоо барьж, тусламж авагчдаар хийлгэж болох ажлыг мэдэж ав.



# НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖУУД

## **Судрууд**

Судруудын Удирдамж дахь дараах сэдвүүдийг үз —

Энэрэл  
Үйлчлэл  
Хөдөлмөр  
Агуулах  
Ядуу, ядуус  
Бишоп  
Өглөг өгөх  
Ажил  
Мацаг барилт  
Өгөөмөр, өглөгч чанар  
Халамж

## **Дуу бичлэгийн материалууд**

*Applying Welfare Principles in Our Lives*  
(дүрс бичлэг, VNV174A)

## **Гарын авлагууд**

*Welfare Services Resource Handbook*  
(PGWE1282)

*Бишопын Удирдамж* (PBCT0124)

## **Сүмийн ном хэвлэл дэх өгүүллүүд**

Ромни, Марион Г. In Conference Report, Oct. 1977 оны 10-р сар, х. 114–118. (Мөн *Ensign*, 1977 оны 11-р сар, х. 79–81).

Ромни, Марион Г. In Conference Report, 1979 оны 10-р сар, х. 137–141. (Мөн *Ensign*, 1979 оны 11-р сар, х. 94–96).

Монсон, Томас С. In Conference Report, 1980 оны 10-р сар, х. 129–134. (Мөн *Ensign*, 1980 оны 11-р сар, х. 89–91).

Монсон, Томас С. "Guiding Principles of Personal and Family Welfare," *Ensign*, 1986 оны 9-р сар, х. 3–5.

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN



4 02322 94363 6

32294 363